



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 12 сарын 14 өдөр

Дугаар А/Б/11

Арвайхээр

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль 29.2, 29.1.3.л, Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлигийн 1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг Өвөрхангай аймагт зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд: (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)

(Аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

(Аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

(Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

(Сум дундын Ойн ангийн дарга)

(“Голомт нутгийн эзэд” ТББ)

Нарийн бичгийн дарга: (Аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Ойн нэгжийн дарга)

2.“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 2021-2030 оноор боловсруулж, батлуулан хэрэгжилтийг жил бүр аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд тайлагнаж ажиллахыг ажлын хэсэгт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101297